



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/9/СТА/ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.03.15 № 11376

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 7

“БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.БАТЦЭРЭН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем

• 005020314

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.1. Оршил

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал С.Батцэрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-наас 2020 оны 03 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 02 дүгээр сарын 10-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь “Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчинг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Ординат” ХХК-ны Винница программ хангамж ашигладаг байна.

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 24 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 23 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019

оны жилийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 2 хувь буюу 79249.4 мянган төгрөгөөр тооцов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурь төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлын өөрчлөөгүй байна.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,624.2 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, богино ба урт хугацаат өрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	125,432.5	78,575.8	-46,856.7
Авлага	932,939.8	1,025,977.6	93,037.7
Урьдчилгаа		406.2	406.2
Бараа материал	390.3	524.1	133.8
Үндсэн хөрөнгө	3,040,896.8	3,129,152.1	88,255.3
Хуримтлагдсан элэгдэл	-104,564.6	-272,165.2	167,600.6
Нийт хөрөнгө	3,995,094.9	3,962,470.6	-32,624.2
Богино хугацаат өр төлбөр	49,566.6	75,777.4	26,210.8
Урт хугацаат өр төлбөр	1,010,000.0	1,077,394.0	67,394.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,935,528.3	2,809,299.2	-126,229.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,995,094.9	3,962,470.6	-32,624.2

Авлага дансны үлдэгдэл 93037.7 мянган төгрөгөөр өссөн нь 2017-2018 онд олгосон зээлийн эргэн төлөлтөөс 192,912.1 мянган төгрөг харилцах дансанд төвлөрсөн ба Аймгийн Засаг даргын 2019.07.05-ны өдрийн А/370 дугаар захирамжаар 15 иргэнд 160,000.0 мянга, 2019.11.07-ны өдрийн А/568 дугаар захирамжаар 5 иргэнд зээл олгох шийдвэр гарч 4 иргэнд 39,000.0 мянга, 2019.04.25-ны өдрийн А/240 дугаар захирамжаар аймгийн ангилагдаагүй зардлаас жишиг өрхийн жимс жимсгэнэ тариалах төсөлд 50,000.0 мянга, нийт 249,000.0 мянган төгрөгийн зээлийн тайлант онд олгосонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 133.8 мянган төгрөгөөр өссөн нь түлш шатах тослох материалын үлдэгдэл 291.9 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 88,255.3 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламжид 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжөөр 16141.4 мянган төгрөгийн худгийн барилгыг орлого авсан байна. Мөн 2347,4 мянган төгрөгийн хөрөнгө

худалдан авсан, аймгийн ЗДТГ-аас 75616,5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг шилжүүлэн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 26210,8 мянган төгрөгөөр өссөн нь татварын өглөг 2687.3 мянга, байгууллагад төлөх өглөг 11735.2 мянга, урьдчилж орсон орлого буюу зээлийн хяналтын зардал 13304,1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд аймгаас ЖДҮ дэмжих зорилгоор тус байгууллагаар дамжуулан олгож байгаа зээлийг бүртгэж байгаа ба тайлант онд 67394.0 мянган төгрөгөөр өссөн нь 2019.04.25-ны өдрийн А/240 дугаар захирамжаар аймгийн ангилагдаагүй зардлаас жишиг өрхийн жимс жимсгэнэ тариалах төсөлд 50,000.0 мянга, 2015-2016 онд олгосон зээлээс төлсөн Эрдэнэ-өвөр 9,000.0 мянга, Баянхонгор контракшин 8,400.0 мянган төгрөгийг дансанд өглөгөөр тусгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 126,229.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүн 201,665.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

2.10. Зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 сарын 17-ны өдрийн 01 дугаар дугаар тогтоолоор тус байгууллагын 2019 оны бизнес төлөвлөгөө, хяналтын зардлын хуваарилалтыг баталсан байна. Уг тогтоолоор үйл ажиллагааны борлуулалтын орлого 83416.2 мянга, зардлыг 297817.0 мянга нийт алдагдлыг 214400.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 2 Зардлын гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мян.төг/ зөрүү
Төсөл хөтөлбөр	1,500.0	1,257.5	242.5
Түрээсийн орлого	81,916.2	59,333.7	22,582.5
Бусад орлого	-	23,408.8	(23,408.8)
Орлогын дүн	83,416.2	84,000.0	(583.8)
Цалин	81,011.0	68,122.5	12,888.5
НДШ	10,126.3	8,336.5	1,789.8
Бусад зардал	206,679.7	209,206.5	(2,526.8)
Зардлын дүн	297,817.0	285,665.5	12,151.5
	(214,400.8)	(201,665.5)	(12,735.3)

Бизнес төлөвлөгөөгөөр 83416.2 мянган төгрөгийн орлого батлагдаж гүйцэтгэлээр 84000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Мөн 297817.0 мянган төгрөгийн зардал батлагдаж 285665.5 мянган төгрөгийн зардал гарч 201665.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 23 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 24 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 24 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 22 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ

Аудитаар нийт 229,682.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 219,579.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10,103.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Хүснэгт 3.Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /мянган.төг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	7525.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	219579.7	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	227105.3	

Аудитаар дараах 219,579.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 2019 оны үлдэгдэл 1,008,518.7 мянган төгрөгийн авлагаас 2017 онд олгосон 9 зээлдэгчийн 129,716.1 мянга, 2018 онд олгосон 8 зээлдэгчийн 87,863.6 мянга нийт 219,579.7 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн зээл байна.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.8-т “Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх”, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн гэрээний 5.2-т заасан зээлдэгчийн үүргээ биелүүлээгүй, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар байрны түрээсийн орлогыг дансанд бүрэн төвлөрүүлээгүй, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчил илэрч 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Түрээсийн авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан эсэх, жижиг, дунд үйлдвэрийн зээлийн авлагыг хугацаандаа төлөгдөж байгаа эсэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 53 мэдээллийг хугацаанд нь, 47 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	4	4	1	3	
2	Сар бүр	2	24	17	7	
3	Тухай бүр	6	72	35	37	
	Нийт	12	100	53	47	

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт гүйцэтгэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэсэн бүтэн жилээр мэдээлэх 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Сар бүр мэдээлэх мэдээллээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө 1,2,3-р сарууд, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1,2,3,11 дүгээр саруудад тус тус хоцроож байршуулсан байна.

Тухай бүр байршуулах мэдээллээс тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 1,2,3,11 дүгээр сарууд, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 1,2,3,8,11 дүгээр сарууд, бонд, зээл, өрийн бичиг баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, үүссэн аливаа шийдвэр 1,2,3,5,8 дугаар сарууд, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 1,2,3,4,5,6,7,8,11 сарууд, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 1,2,3,11 дүгээр сарууд, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 1,2,3,5,6,8 дугаар саруудад тус тус хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан ба тус байгууллагын гүйцэтгэх захирлын 2019 оны 6 сарын 10-ны 49 тоот албан бичгээр хэрэгжүүлсэн тухай хариуг ирүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 заалт, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тухайн тайлант оны эхэнд ЖДҮ-ын авлага 918,229.5 мянган төгрөгийн авлагатай байсан ба тайлант хугацаанд 275,201.2 мянган төгрөгийн авлага шинээр үүсэж 2019 онд 1,008,518.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба 2017 онд олгосон зээлээс 129,716.1 мянга, 2018 онд 87,863.6 мянга нийт 219,579.7 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй байхад хяналт тавьж ажиллаагүй байна. 2019 оны санхүүгийн тайланд түргэн хөрвөх чадварын харьцаагаар шинжилгээ хийж үзэхэд 0.76 гарч байна. Энэ нь зээлийн эргэцийн хугацаа удааширч төлбөрийн чадваргүй болж байгааг харуулж байна

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх, зээл хугацаандаа төлөгдөөгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төлбөрийн чадварыг сайжруулж, түргэн хөрвөх чадварын харьцааг хэвийн түвшинд хүртэл зээл олголтыг зогсоож, жижиг, дунд, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож байгаа зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хоцорсон зээлийг нэн даруй төвлөрүүлэх арга хэмжээг авах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст 24812,7 мянган төгрөгийн түрээсийн авлагын үлдэгдэлтэй байгаа ба аудитаар түрээсийн гэрээгээр төлөх дүнг төлсөн мөнгөн дүнтэй тулган шалгахад нягтлан

бодогч авлагыг 7525.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, тооцооллыг харилцагч бүртэй хийгээгүй, тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулаагүй байна:

2.2. Эрсдэл:

Түрээсийн орлогыг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

ЖДҮ-ийн ажилсаг төвийн байрны 2018-2019 онуудын түрээсийн гэрээ, төвлөрсөн орлогын тооцоог дахин хийж, авлагыг тулган баталгаажуулж, тооцоо акт үйлдэн, төлбөрийг бүрэн барагдуулах ажлыг зохион байгуулах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	3,995,094,882.00	3,962,470,636.91
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,058,762,721.62	1,105,483,754.54
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	125,432,536.57	78,575,809.91
1.1.2	Дансны авлага	14,640,410.58	24,812,711.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	69,870.50	646,156.96
1.1.4	Бусад авлага	918,229,566.00	1,000,518,695.08
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	390,337.97	524,137.59
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,058,762,721.62	1,105,483,754.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,824,622,160.38	2,745,276,882.37
1.2.2	Биет бус хөрөнгө	111,710,000	111,710,000
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,936,332,160.38	2,856,986,882.37
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,995,094,882.00	3,962,470,636.91
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	3,995,094,882.00	3,962,470,636.91
2.1	Өр төлбөр	1,059,566,589.37	1,153,171,127.26
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	49,566,589.37	75,777,433.26
2.1.1.1	Дансны өглөг	50,176.23	11,735,211.10
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	29,516.07	2,687,302.16
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	48,050,860.00	61,354,920.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	49,566,589.37	75,777,433.26
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,010,000,000.00	1,077,394,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,010,000,000.00	1,077,394,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,059,566,589.37	1,153,171,433.26
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	3,23,983,717.36	3,099,420,127.36
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	111,759,000.00	111,759,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-88,455,424.73	-290,120,923.71
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,935,528,292.63	2,809,299,203.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,995,094,882.00	3,962,470,636.91

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	103,742,022.58	84,000,000.00
2	Борлуулалтын өртөг	168,191,699.38	242,596,958.38
3	Нийт ашиг (алдагдал)	-64,449,676.80	-158,596,958.38
10	Ерөнхий ба удирдлагын зардал	47,904,681.13	50,103,036.28
17	Бусад ашиг (алдагдал)	14,490,043.42	7,034,495.68
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-97,864,314.51	-201,665,498.98
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-97,864,314.51	-201,665,498.98
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-97,864,314.51	-201,665,498.98

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнө	2019 оны 12-р сарын 31 /төгрөг/
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,168,221,507.72	552,302,154.70
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,329,005.00	101,867,343.44
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	46,890,384.00	100,256,000.00
	Бусад мөнгөн орлого	1,050,366,618.72	350,178,811.26
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,074,012,673.50	599,158,881.36
	Ажиллагчдад төлсөн	43,374,694.00	52,724,721.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,908,110.59	17,438,608.64
	Бараа материал худалдан авахад төлсөн	20,521,496.00	17,376,159.00
	Ашиглалтын зардалд төлсөн	23,831,249.95	30,313,682.20
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,293,500.00	2,434,700.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	4,132,409.35	7,117,211.86
	Даатгалын төлбөрт төлсөн		14,250,000.00
	Бусад мөнгөн зарлага	965,951,213.61	457,503,792.66
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	94,208,834.22	46,856,726.66
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	94,208,834.22	46,856,726.66
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,223,702.35	125,432,536.57
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	125,432,536.57	78,575,809.91

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20.... оны ..-р сарын ...-ний үлдэгдэл	5,000,000.00	799,000.00	9,408,889.78	15,207,889.78
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл	5,000,000.00	799,000.00	9,408,889.78	15,207,889.78
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт	2,912,224,717.36	111,960,000.00		3,018,184,717.36
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	20.... оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,912,224,717.36	111,759,000.00	-88,455,424.73	2,935,528,292.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл	2,912,224,717.36	111,759,000.00	-88,455,424.73	2,935,528,292.63
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-201,665,498.98	-201,665,498.98
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт	75,436,410.00			75,436,410.00
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	20.... оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,987,661,127.36	111,759,000.00	-290,120,923.71	2,809,299,203.65

4.5 Зардлын гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	төсөл хөтөлбөр	1,500.0	1,257.5	242.5
2	Түрээсийн орлого	81,916.2	59,333.7	22,582.5
	бусад орлого	-	23,408.8	-
3	Борлуулалтын дүн	83,416.2	84,000.0	(583.8)
4	Цалин	81,011.0	68,122.5	12,888.5
5	НДШ	10,126.3	8,336.5	1,789.8
6	Цахилгааны зардал	16,958.0	12,515.8	4,442.2
7	Нүүрсний зардал	3,828.0	3,124.3	703.7
8	тээврийн зардал	4,284.0	1,712.6	2,571.4
9	Цэвэр бохир усны зардал	2,810.0	180.4	2,629.6
10	засвар үйлчилгээний зардал	6,000.0	1,741.8	4,258.2
11	Элэгдэлийн зардал	152,359.9	166,973.9	(14,614.0)
12	ариутгал цэвэрлэгээ	901.1	817.5	83.6
13	гамшиг нөөцийн зардал	740.5	111.9	628.6
14	Буцалтгүй тэтгэмж	500.0	-	500.0
15	Хөдөлмөр хамгаалал	2,540.0	246.6	2,293.4
16	Бичиг хэрэг	2,331.5	1,267.1	1,064.4

17	Шуудан холбоо	1,200.0	688.6	511.4
18	Шатахуун	2,880.0	1,544.8	1,335.2
19	Урсгал засвар	299.7	16.0	283.7
20	сургалтын зардал	1,200.0	1,387.5	(187.5)
21	Биеийн тамир уралдаан тэмцээний зардал	1,033.0	877.1	155.9
22	ТУЗ-ын зардал	4,524.0	1,820.0	2,704.0
23	Шагнал урамшуулал	990.0	1,820.0	(830.0)
24	Бусад зардал	400.0	1,342.2	(942.2)
25	Албан томилолт	900.0	370.0	530.0
	Халаалтын зардал	-	10,648.5	(10,648.5)
26	Нийт зардлын дүн	297,817.0	285,665.5	12,151.5
27	Нийт ашиг алдагдал	(214,400.8)	(201,665.5)	(12,735.3)

Бэлтгэсэн:

АУДИТОР



Н.БҮНЧИНСҮРЭН

Огноо: 2020.03.15

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР




А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.03.15

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Огноо: 2020.03.15